

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2013 оны 2 дугаар сарын 20

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2012 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын салбартүйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

| /тоогоор/ | | | | | |
|-----------|-----------------------------|-------------|----------------|----------------|-------------|
| № | Тусгай зөвшөөрөл эзэмшигчид | 2012-11 сар | Нэмэгдсэн | Хасагдсан | 2012-12 сар |
| 1 | Даатгалын компани | 18 | | | 18 |
| 2 | Даатгалын компанийн салбар | 219 | | 6 ¹ | 213 |
| 3 | Даатгалын төлөөлөгч | 2348 | 9 ² | | 2357 |
| 4 | Даатгалын зуучлагч | 15 | 2 ³ | | 17 |
| 5 | Даатгалын хохирол үнэлэгч | 9 | | | 9 |
| 6 | Актуарч | 15 | | | 15 |
| 7 | Бусад | 15 | | | 15 |

¹ Хорооны даргын 2012 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 251 дүгээр тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-ийн Баянзүрх дүүрэг дэх салбар, “Жонон даатгал” ХХК-ийн Хэнтий аймаг дахь салбар, “Номин даатгал” ХХК-ийн Архангай аймаг дахь салбар, “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн Өмнөговь аймаг дахь салбар, “Мандал женерал даатгал” ХХК-ийн Төв аймаг дахь салбар, “Монре даатгал” ХХК-ийн Өвөрхангай аймаг дахь салбаруудыг тус тус хүчингүй болгох шийдвэр гаргасан байна.

² Хорооны даргын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 263 дугаар тушаалаар “Мандал женерал даатгал” ХХК-д 9 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.

³ Хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 382 дугаар тогтоолоор “Эрсдэлийн шийдэл” ХХК-д, 386 дугаар тогтоолоор “Хасбанк” ХХК-д тус тус даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


Даатгалын байгууллагуудын 2012 оны 12 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг тайлант үеийн өссөн дүнтэй харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :


| /төгрөгөөр/ | | |
|-------------------------------------|------------------|--------------------|
| Үзүүлэлт | 2012.12.31 /сар/ | 2012.12.31 /өссөн/ |
| Даатгалын нийт хураамж | 7,569,446,252.16 | 75,821,569,002.73 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан | 601,911,802.36 | |

| | | |
|--|--------------------|----------------------|
| журмын даатгалын хураамж | | 14,545,280,602.64 |
| Олгосон нийт нөхөн төлбөр | 2,427,561,849.13 | 16,304,018,232.62 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр | 1,099,301,446.00 | 4,258,537,227.60 |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо | 2,410.00 | 9,521.00 |
| Давхар даатгалд төлсөн хураамж | 1,481,543,085.13 | 15,819,686,957.75 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо | 17,820.00 | 430,540.00 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо | 7,826.00 | 300,912.00 |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо | 7,054.00 | 348,278.50 |
| Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 112,160,800,000.00 | 4,792,751,788,454.70 |
| Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр | 79,740,590.00 | 379,615,258.98 |

2012 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын хураамжийн орлого 2011 оны мөн үеийнхээс 2193.0 сая төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна. Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого өмнөх сараас 229.5 сая төгрөгөөр буюу 1.4 дахин буурсан байна. Оны эхний 12 дугаар сарын байдлаар нийт 14,319.9 сая төгрөг болсон байна.




2012 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын нөхөн төлбөр 2011 оны мөн үеэс 1273.1 сая төгрөгөөр буюу 2.1 дахин өссөн. Жолоочийн албан журмын даатгалын нөхөн төлбөр өмнөх сараас 1.3 дахин өссөн байна.




Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

| Үзүүлэлт | /Төгрөгөөр/ | |
|---|---------------------------|---------------------------|
| | 2012.12.31 /сарын дүн/ | 2012.12.31 /өссөн дүн/ |
| Даатгалын нийт хураамж | 71,514,212.00 | 801,041,027 |
| Олгосон нийт нөхөн төлбөр | 9,410,553.00 | 136,335,413 |
| Давхар даатгалд төлсөн хураамж | 1,573,830.00 | 50,509,979 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо | 15.00 | 205 |
| Хувь хүний хугацаат даатгалд | 1.00 | 54 |
| Байгууллагын хугацаат даатгалд | 1.00 | 19 |
| Өндөр хамгаалалттай ЭМД-д | | 2 |
| Эмнэлгийн мөнгөний даатгалд | 12.00 | 56 |
| Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд | | 40 |
| Тэтгэврийн даатгалд | 1.00 | 18 |
| Орон сууцны даатгалд | | 4 |
| Хуримтлалын даатгалд | | 12 |
| Зээлдэгчийн амь насны даатгалд | | 0 |
| Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 40,000,000.00 | 500,000,000.00 |
| Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн | 3,000,000.00 | 12,510,000 |



Урт хугацааны даатгагчийн даатгалын хураамжийн орлого 2012 оны 12 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 3.74 дахин буюу 52.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.



2012 оны 12 дугаар сарын байдлаар урт хугацааны даатгалын нөхөн төлбөр 2011 оны мөн үеэс 1.1 дахин буурсан байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

| Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|---|---------------------------|---------------------------|
| | 2012.12.31 /сарын дүн/ | 2012.12.31 /өссөн дүн/ |
| Даатгуулагчаас шууд орж ирсэн дүн даатгалын хураамж | 101,302,797.00 | 726,404,946.50 |
| Даатгалын зуучлагчийн орлого | 101,302,797.00 | 547,037,236.00 |
| Зуучилсан даатгалын гэрээний тоо | 4.00 | 5,038.00 |

Зуучилсан даатгалын
гэрээнүүдээс хамгийн өндөр
үнэлгээний дүн

6,683,350,000.00

2012 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 101.3 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Хаан банк” ХХК, “Пийс оф лайф” ХХК, “Жомолхари” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Изи инвестмент” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Асимон брокерс” ХХК-иуд тус тус 12 дугаар сарын мэдээг ирүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2012.12.31 /сарын дүн/ | 2012.12.31 /өссөн дүн/ |
|---|---------------------------|---------------------------|
| Даатгалын хохирол үнэлсэний орлого | 39,884,905.00 | 214,549,218.00 |
| Үнэлсэн даатгалын хохирлын тоо | 36,637,917.00 | 82,224,101.00 |
| Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн | 3,022,000.00 | 143,841,281 |

2012 оны 12 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 36.6 сая төгрөгийн орлоготой ажиллаж, өмнөх сарын мөн үеэс 12.0 сая төгрөгөөр буурсан байна.

“Файн эстимэйт” ХХК, “Мега марз” ХХК, “Гэрэгэ эстимэйт” ХХК-иуд тус тус 12 дугаар сарын мэдээг ирүүлээгүй байна.

БУСАД

Хорооны 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 355 дугаар тогтоолоор “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, 356 дугаар тогтоолоор “Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг шинэчлэн батлах тухай, 358 дугаар тогтоолоор “Албан журмын даатгагчдын холбооны үрэм” -д нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, 357 дугаар тогтоолоор “Хорооны 2009 оны 275 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай”, 359 дүгээр тогтоолоор “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилох томилохыг зөвшөөрөх тухай, 360 дугаар тогтоолоор “Соёмбо даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай, 361 дүгээр тогтоолоор “Даатгуулагчид сугалаа, бэлэг, урамшуулал олгохыг хориглох тухай”, 366 дугаар тогтоолоор “Бодь даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, 375 дугаар тогтоолоор “Номин даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, 376 дугаар тогтоолоор “Моннис даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай шийдвэрүүд тус тус гаргасан байна.

Хорооны 12 дугаар 26-ны өдрийн 377 дугаар тогтоолоор “Даатгалын салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлах тухай, 378 дугаар тогтоолоор “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам”-ыг шинэчлэх батлах тухай, 381 дүгээр тогтоолоор “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн өрөнгийг шилжүүлэх зарцуулах журам” -д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 387 дугаар тогтоолоор “Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 389 дүгээр тогтоолоор “Хорооны 2009 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, 390 дүгээр тогтоолоор “Хаан даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг

зөвшөөрөх тухай, 391 дүгээр тогтоолоор “Ган зам даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, 392 дугаар тогтоолоор “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам” батлах тухай, 393 дугаар тогтоолоор “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар” батлах тухай, 394 дүгээр тогтоолоор “Монре даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, 395 дугаар тогтоолоор “Соёмбо даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, 396 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай, 397 дугаар тогтоолоор “Мандал женерал даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай шийдвэрүүд тус тус гаргасан байна.

Хорооны даргын 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 243 дугаар тушаалаар “Бест эстимэйт” ХХК-д хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтэцдээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай тушаалаар шийдвэрлэсэн байна.

ДААТГАЛЫН ГАЗАР